



МОНГОЛБАНК АЖИЛТАН ШАЛГАРУУЛЖ АВНА.

Үндэсний цахим гүйлгээний төвд дараах ажлын байранд ажилтан шалгаруулж авна.

СИСТЕМИЙН ШИНЖЭЭЧ

Ажлын байранд тавих шаардлага:

- Компьютерийн Техник/Програм хангамж, Электроник, Холбооны инженер, Хэрэглээний математик, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Өгөгдлийн сан удирдан зохион байгуулах чадвартай (Oracle, Microsoft SQL)
- SQL хэлний мэдлэгтэй
- Microsoft болон Linux үйлдлийн системүүдтэй ажиллах чадвартай (Microsoft, Linux болон CISCO сертификаттай бол давуу тал болно)
- Програмчлалын хэлний зохих мэдлэгтэй (C, Java, UML болон Visual түвшний хэлний мэдлэгтэй бол давуу тал болно)
- Англи хэл дээр мэргэжлийн материал ашиглах чадвартай

Ерөнхий шаардлага:

- Идэвхи санаачлагатай, бүтээлч сэтгэлгээтэй, хариуцлагатай
- Харьцааны соёлтой, хувийн зохион байгуулалт сайтай байх
- Тогтвор суурьшилтай ажиллах
- Багаар ажиллах чадвартай

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет,
- Дунд болон их, дээд сургуулийн дипломын хуулбар (нотариатаар баталгаажуулсан),
- Иргэний үнэмлэхний хуулбар (нотариатаар баталгаажуулсан),
- Өмнө ажиллаж байсан бол тухайн байгууллагын тодорхойлолт

Шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн Монголбанкны Төв байрны бичиг хэрэгт авчирч өгнө үү.

Материал хүлээн авах хугацаа: 2013 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор

Ирүүлсэн материалыг буцаахгүй бөгөөд зөвхөн урьдчилсан шалгаруулалтад тэнцсэн хүмүүстэй буцаж холбоо барих тул харилцах утас, хаягаа төрийн албан хаагчийн анкетад тодорхой бичнэ үү.

Нэмэлт мэдээллийг 324986, 326998 утсаар авч болно.